

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж

2.1.Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Геодези, зураг зүйн салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

3.1.Геодези, зураг зүйн салбарт төрийн үйлчилгээ үзүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

3.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрлийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулах;

3.1.2.геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах;

3.1.3.геодези, зураг зүйн үйл ажиллагааг солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэх;

3.1.4.хэмжлийн нэгдмэл байдлыг хангах.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“байр зүйн зураг” гэж газрын гадарга, түүний дээрх болон доорх объектыг тусгагт оруулан, тодорхой масштабаар жижигрүүлэн буулгаж, таних тэмдгээр дүрсэлж, шинж чанарыг нь илэрхийлсэн газрын зургийг;

4.1.2.“байрлалын сүлжээ” гэж энэ хуульд заасны дагуу солбицлын тогтолцоог байгуулах болон (буюу) тархаан өтгөрүүлэхэд ашиглагддаг геодезийн цэг тэмдэгтийн цогц тогтолцоог;

4.1.3. “геодези” гэж дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний гадаргын шилжих хөдөлгөөнийг тодорхойлох, газрын гадаргын хэсгийг зураг болгон буулган дүрслэх зорилгоор од, нар, хиймэл дагуул болон газрын зургийн багаж хэрэгслийн тусламжтайгаар тухайн цэгийн байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг хэмжин тодорхойлж математик боловсруулалт хийх цогцолбор үйл ажиллагааг;

4.1.4. “геодезийн байнгын цэг, тэмдэгт” гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн

гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв болон түүн дээрх байгууламжийг;

4.1.5.“геодезийн байнгын ажиллагаатай станц” гэж хиймэл дагуулын навигацийн системээс дохио мэдээлэл хүлээн авч, боловсруулан солбицол тодорхойлох зориулалттай байнгын тасралтгүй үйл ажиллагаатай геодезийн байгууламжийг;

4.1.6.“геодезийн сүлжээ” гэж байрлалын, өндрийн ба гравиметрийн сүлжээг хамтад нь ойлгоно;

4.1.7.“газрын зураг” гэж энэ хуульд заасан шаардлагын дагуу дэлхийн гадаргуу, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижигрүүлэн буулгаж дүрсэлснийг;

4.1.8.“газрын зургийн нэг маягийн суурь” гэж жижиг масштабын газрын зураг зохиоход ашиглах нийтлэг өгөгдөл агуулсан зургийг;

4.1.9.“гүйцэтгэлийн зураг” гэж шинээр болон өөрчлөн барьж байгуулсан объект, зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн бодит байршлыг газрын гадаргын өөрчлөлттэй нь харуулсан байр зүйн болон дэвсгэр зургийг;

4.1.10.“газар зүйн нэр” гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон нэрийг;

4.1.11.“дэвсгэр зураг” гэж газрын гадарга, барилга болон инженерийн байгууламжийн бодит байршлыг тусгагт оруулаагүй, газрын гадаргын махиаг тооцолгүй хэмжиж, хэвтээ хавтгайд дүрсэлснийг;

4.1.12.“зураг зүй” гэж газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцаа хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагааг

4.1.13.“зурагжуулах” гэж төрөл бүрийн масштабтай байр зүйн болон бусад газрын зургаар нутаг дэвсгэрийг дүрслэх цогцолбор үйл ажиллагааг;

4.1.14.“масштаб” гэж газрын зурагт дүрсэлсэн хэрчмийн уртыг уг хэрчмийн газар дээрх уртын харьцааг \газрын зураг, газар дээрх хэрчмийн уртын харьцааг\;

4.1.15.“Референц эллипсоид” улс орны нутаг дэвсгэрийн бодит гадаргууг бүхэлд нь эсвэл түүний хэсэгт хамгийн их нийцтэй байхаар тодорхойлсон эсвэл сонгосон эллипсоидыг

4.1.16.“солбицлын тогтолцоо” гэж орон зайн цэгүүд ба тэдгээрийн солбицлын тоон утгыг эхлэлийн цэгээс харьцуулан тогтоосон дүрмийг;

4.1.17.“сэдэвчилсэн газрын зураг, атлас” гэж газрын зургийн нэг маягийн суурь ашиглан зохиосон тухайлсан агуулга, зориулалт бүхий газрын зураг, атласыг;

4.1.18.“өндрийн сүлжээ” гэж нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд өндрийн тогтолцоог байгуулах болон өтгөрүүлэх зорилгоор ашиглах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн олонлогийг;

4.1.19.“гравиметрийн сүлжээ” гэж нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний хурдатгалын утгыг нь тодорхойлсон геодезийн байнгын цэг, тэмдэгтийн олонлогийг;

4.1.20.“Эхлэл өгөгдөхүүн” гэж референц эллипсоид дээрх эхлэл цэгийн геодезийн уртраг, өргөрөг, эхлэл чиглэлийн геодезийн азимут, эхлэл цэг дээрх эгц босоо шугамын хазайлтын байгуулагч, эхлэл цэгийн геоидын/квазигеоидын өндрийг;

4.1.21. “геодезийн хэмжлийн багаж” гэж өнцөг, өндөр, зай, хүндийн хүчний хурдатгал болон цэгийн байрлалыг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр тодорхойлох багажийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ,

ТАВИГДАХ ШААРДЛАГА

5 дугаар зүйл.Геодези, зураг зүйн үйл ажиллагаа

5.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна.

5.1.1.газрын гадаргуугийн цэг, орон зайн биетийн солбицол, өндрийг тодорхойлох, тэдгээрийн орон зайн харилцан байршлыг нь тогтоох зорилгоор геодезийн хэмжилт боловсруулалт хийх, эдгээр солбицол, өндрийн утгын цаг хугацааны өөрчлөлтийг тогтоох, Дэлхийн хэлбэр хэмжээ ба түүний хүндийн хүчний таталцлын талбарыг тодорхойлох, улсын геодезийн сүлжээний эхлэл цэг, байрлалын, өндрийн ба гравиметрийн сүлжээ байгуулах;

Тайлбар: Улсын геодезийн сүлжээ гэдэгт байрлалын, өндрийн ба гравиметрийн сүлжээг хамтад нь ойлгоно.

5.1.2.үндэсний референц эллипсоид, солбицол, өндрийн тогтолцоо, геоидын өндрийн загвар, тусгагийг тодорхойлох;

5.1.3.улсын байрлалын, өндрийн ба гравиметрийн сүлжээний цэгүүдийг шинээр байгуулах, сэргээн босгох, цэгүүдийн нягтрал, нарийвчлалыг сайжруулах, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах;

5.1.4.Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулах, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон дэвсгэр зураг зохиох, шинэчлэх;

5.1.5.зайнаас тандан судлах, агаар, сансрын зураглал, фотограмметрийн боловсруулалт хийх;

5.1.6.улсын хилийн баганын байршлыг геодезийн аргаар тодорхойлох, хилийн шугамыг зураглах;

5.1.7.нуур, гол, усан сан болон тэдгээрийн гүнийг зураглах, усан замын байр зүйн зураг зохиох;

5.1.8.геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг байгуулах, баяжуулах, хөтлөх;

5.1.9.үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг суурь өгөгдөл, мэдээллээр хангах;

5.1.10.сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиох, хэвлэх;

5.1.11.газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, зөв бичих, галиглах, газрын зурагт тусгах, нэрийн зураг үйлдэх, мэдээллийн сан үүсгэх, жагсаалт хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх;

5.1.12.өндөр уулсын ноёлох оргилын солбицол, өндрийг тодотгон тогтоох, экологийн тогтолцооны газрын зураг зохиох, шинэчлэх;

5.1.13.газар, хот байгуулалт, инженерийн шугаман байгууламжийн, геологи, уул уурхай, хөдөө аж ахуйн болон бусад бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх,

5.1.14.инженерийн дэд бүтцийн төлөвлөлт, байгуулалт, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт, зураглал үйлдэх,

5.1.15.газрын тос, шатдаг хий, геологи, уул уурхай, ашигт малтмал, геофизикийн хайгуулын геодезийн хэмжилт, байр зүйн болон дэвсгэр зураглал;

5.1.16.хот, тосгон, бусад суурины газрын ерөнхий төлөвлөгөө, тохижилтын байр зүйн болон дэвсгэр зураглал үйлдэх, шинэчлэх;

5.1.17.засаг захиргааны нэгж, тусгай хэрэгцээний газрын хилийн эргэлтийн цэгийн солбицлыг тодорхойлох;

5.1.18.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, туршилт явуулах, програм хангамж, багаж тоног төхөөрөмж зохион бүтээх;

5.1.19.улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, гамшиг болон аюул үүсэх нөхцөлд геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх;

6 дугаар зүйл.Монгол Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил

6.1.Батлан хамгаалах, улсын хилийг тодотгох болон эдийн засгийн тусгай бүс нутагт гүйцэтгэж буй үйл ажиллагаанд зориулагдсан геодези, зураг зүйн ажлыг хамааруулна.

6.2.Улсын батлан хамгаалах зорилгоор хийгдэж буй геодези, зураг зүйн ажлыг батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ.

6.3.Улсын батлан хамгаалах зорилгоор хийгдэж буй геодези, зураг зүйн ажлыг зохион байгуулахад шаардлагатай батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг, хариуцлага, хоорондын харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

7 дугаар зүйл.Солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо,

7.1.Геодезийн **хэмжил**, зураглалын ажлыг олон улсын, улсын, ~~орон нутгийн, бие даасан~~ **солбицол**, өндөр, гравиметрийн тогтолцоонд гүйцэтгэнэ.

7.2.Олон улсын солбицлын тогтолцоонд Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт заасан тогтолцоо, мөн гадаад орнуудын хиймэл дагуулын навигацийн системийн солбицлын тогтолцоо хамаарна.

7.3.Улсын геодезийн солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоо, геодезийн сүлжээний эхлэл цэгийн утгыг Засгийн газар батална.

7.4.Солбицлын бие даасан тогтолцоог инженерийн геодезийн, эрдэм шинжилгээ, судалгааны геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглаж болно.

7.5.~~Бие даасан солбицлын тогтолцоонд гүйцэтгэсэн хэмжил, зураглалыг улсын солбицлын тогтолцоонд заавал хөлбөнө.~~

7.6.Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглах улсын солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, эдгээрийг тодорхойлоход шаардлагатай Дэлхийн хэлбэр хэмжээ, хүндийн хүчний хэмжигдэхүүн ба бусад үзүүлэлтийг, эдгээр солбицлын тогтолцоо болон бие даасан, олон улсын солбицлын тогтолцооны хоорондох хөрвүүлэлтийн үзүүлэлтийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхойлон тогтоож, төрийн захиргааны төв байгууллага батална.

8 дугаар зүйл.Геодезийн сүлжээ

8.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээг байгуулна.

8.2.Улсын геодезийн ~~байрлалын, өндрийн, гравиметрийн нэгдсэн~~ сүлжээг батлагдсан **энэ хуулийн 7,3-д заасан** геодезийн **нэгдсэн** тогтолцоонд, геодезийн сүлжээний эхлэл цэгт тулгуурлан байгуулна.

8.3.Улсын геодезийн сүлжээний бүрэлдэхүүнд геодезийн хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах байнгын ажиллагаатай станц багтана.

8.4.Улсын геодезийн байрлалын тулгуур сүлжээг 6 жилд, өндрийн болон гравиметрийн тулгуур сүлжээг 15 жилд давтан хэмжиж шинэчлэх бөгөөд хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдолд тухай бүр сүлжээг давтан хэмжинэ.

8.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт ~~Улсын~~ геодезийн ~~байрлал, өндөр, гравиметрийн~~ сүлжээг байгуулах, ~~эдгээр~~ сүлжээний цэг тэмдэгтийг суулгах, өтгөрүүлэх, нягтралын тогтоогдсон хэм хэмжээг мөрдлөгө болгон хэрэгжүүлэх ажлыг геодези, зураг зүйн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

8.6.Улсын геодезийн ~~байрлал, өндөр, гравиметрийн~~ сүлжээний цэг тэмдэгтийн техникийн үзүүлэлтэд хяналт үнэлгээ, мониторинг хийх ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

8.7.Улсын геодезийн ~~байрлал, өндөр, гравиметрийн~~ сүлжээний цэг тэмдэгтийн тухай мэдээ мэдээлэл, дүгнэлтийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны цахим мэдээллийн санд байршуулна.

8.8.Улсын геодезийн ~~байрлал, өндөр, гравиметрийн~~ сүлжээний цэг тэмдэгтийн техникийн үзүүлэлтэд хяналт үнэлгээ, мониторинг хийх дүрэм, журам болон тэдгээрийн талаарх мэдээ мэдээлэл, дүгнэлтийн бүрдлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

8.9.Улсын геодезийн ~~байрлалын, өндрийн, гравиметрийн~~ сүлжээний бүтэц болон түүнийг байгуулах, геодезийн цэг тэмдэгтэд тавих шаардлагыг тодорхойлсон норм, дүрмийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ~~төгтөөнө батална.~~

9 дүгээр зүйл. Геодезийн байнгын цэг, тэмдэгт

9.1.Төрийн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр байгуулсан геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч байна.

9.2.Геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, ашиглахад холбогдох стандарт, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан норм, дүрмийг баримтална.

9.3.Байгууллага, аж ахуйн нэгж нь геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулахдаа сум, дүүргийн Засаг дарга болон хил хамгаалах байгууллагатай зөвшилцөнө.

9.4.Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгж нь геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулсан бол уг цэгийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг даргад, тусгай хэрэгцээний газарт бол хариуцсан захирагчид, хилийн зурваст бол хил хамгаалах ерөнхий газрын харьяа тусгай ангийн удирдлагад хүлээлгэж өгнө.

9.5.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь геодезийн байнгын цэг тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Уг цэгийг нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага гарвал түүнийг сэргээн босгох зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

9.6.Геодезийн цэг тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь түүнийг хамгаалах, геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

9.7.Нутаг дэвсгэртээ байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

9.8.Хилийн зурваст байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хил хамгаалах байгууллага, тухайн цэг байрлаж байгаа нутаг дэвсгэр дэх хилийн анги хяналт тавина.

9.9.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан тохиолдолд Засаг дарга, хил хамгаалах ерөнхий газар нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.

9.10.Тусгай хэрэгцээний газарт байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хариуцсан захирагч хяналт тавина.

9.11.Геодезийн цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүс нь цэгийн төвөөс эргэн тойронд 5 метр байна.

10 дугаар зүйл. Газрын зургийн ангилал, төрөл, агуулга, нарийвчлал

10.1. Газрын зурагийг нь тусгай зориулалтын болон нийтийн хэрэгцээний гэжээн ангилалтай байна.

10.1.1. Тусгай зориулалтын газрын нь төрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээллийг агуулсан, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад зориулсан байна.

10.1.2. Нийтийн хэрэгцээний газрын зураг нь энэ хуулийн 10.1.1-д заасан мэдээллийг агуулаагүй байна.

10.2. Тусгай зориулалтын газрын зургийн агуулгыг Засгийн газар батална.

10.3. Газрын зургийг агуулга, зохиож буй арга, зориулалтаас хамааруулан дараах төрөлд хуваана:

10.6.1. байр зүйн зураг;

10.6.2. дэвсгэр зураг;

10.6.3. сэдэвчилсэн газрын зураг.

10.4. Газрын зургийг том буюу 1:100, 1:200, 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000, дунд буюу 1:10 000, 1:25 000, 1:50 000, 1:100 000, 1:200 000, жижиг буюу 1:500 000 ба түүнээс жижиг масштабаар зохиож хэвлэнэ.

10.5. Улсын нийт нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөлтөд жижиг масштабын, бүс нутгийн болон аймгийн хөгжлийн төлөвлөлтөд дунд масштабын, хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтөд том масштабын байр зүйн, хэсэгчилсэн төлөвлөлтөд том масштабтай дэвсгэр зургийг ашиглана.

10.6. Том болон дунд масштабын газрын зургийн нарийвчлал нь байрлалын хувьд тухайн масштабын аравны нэг миллиметр ноогдох хэмжээнээс, өндрийн хувьд үеийн өндрийн гуравны нэг хэмжээнээс тус тус ихгүй байна.

10.7. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан жижиг, дунд масштабын байр зүйн зураг ба хот суурин газрын байр зүйн болон дэвсгэр зураг нь орон зайн биетийн хавтгайн болон өндрийн байршлыг нь тодорхойлох боломжтой, улсын хил, засаг захиргааны нэгжийн хил, газар зүйн нэр, ойн сан, усан сангийн хил, газрын гадаргуу, бусад мэдээллийг агуулах ба батлагдсан солбицол, өндрийн тогтолцоо, тодорхой тусгагт дүрслэгдсэн байна.

10.8. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан жижиг, дунд масштабын байр зүйн зураг, суурин газрын байр зүйн болон дэвсгэр зургийг зохиох, шинэчлэх, ашиглуулах ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн зохион байгуулна.

10.9. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан жижиг, дунд масштабын байр зүйн зураг, ба хот суурин газрын байр зүйн болон дэвсгэр зургийг тоон зураглалын нэгдсэн суурь дахь мэдээ мэдээлэл, мөн Геодези, зураг зүйн нэгдсэн санд хадгалагдаж буй орон зайн өгөгдөл, материалыг ашиглан зохионо.

10.10. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан жижиг, дунд масштабын, хот суурин газрын том масштабын байр зүйн болон дэвсгэр зураг, тэдгээрт дүрслэгдэж буй мэдээ мэдээллийн бүрдэл, таних тэмдэгт тавих шаардлага, тоон хэлбэрт шилжүүлсэн зургийн хэвд тавих шаардлагыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10.11. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан жижиг, дунд масштабын байр зүйн зургийг 10 жилд, хот суурин газрын байр зүйн болон дэвсгэр зургийг нийслэлд 2 жилд, бусад суурин газарт 3 жилд тутамд шинэчилнэ.

10.12. Дэвсгэр зургийг газрын гадаргуугийн махиаг үл тооцсон, газар нутгийн хязгаарлагдмал талбайд том масштабаар үйлдэнэ.

10.13. Сэдэвчилсэн газрын зургийг үндсэн агуулга, дүрсэлж буй сэдвээр зохионо.

10.14. Сэдэвчилсэн газрын зураг, бөжөн атласыг зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж зохионо.

10.15.Сэдэвчилсэн газрын зураг, **бөжөн** атласд тавигдах шаардлагыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

11 дүгээр зүйл.Газар зүйн нэр

11.1.Газар зүйн нэрэнд дараахь объектын нэр хамаарна:

11.1.1.эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр тал, говь, цөл, гол, мөрөн, нуур, тойром зэрэг физик газар зүйн объект;

11.1.2.хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, хөшөө, талбай;

11.1.3.улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний доторх гудамж, байгаль, түүх соёлын дурсгалт газар.

11.2.**Өмнө тогтоосон г**Газар зүйн хуучин нэрийг тодотгох, **эсхүл газар зүйн нэрийг** шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ~~мэргэжлийн хүмүүс~~, **түүх, угсаатан зүй, монгол хэлний эрдэмтэн** судлаачдын саналыг үндэслэнэ.

11.3.Иргэн, хуулийн этгээдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хэвшүүлэх асуудлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран зохион байгуулна.

11.4.Шинээр байгуулсан объектыг нэрлэхэд дараахь зарчим баримтална:

11.4.1.тухайн объектыг нээх, судлах, барьж байгуулахад оролцсон буюу эзэмшиж байгаа хүний нэрээр нэрлэх;

11.4.2.газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэж болох;

11.4.3.ойролцоо орших өөр төрлийн объектууд нь ижил нэртэй байж болох.

11.5.Газар зүйн нэрийг дараах онцгой тохиолдолд өөрчилж болно:

11.5.1.адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;

11.5.2.уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;

11.5.3.тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал.

11.6.Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараах шаардлагыг хангасан байна:

11.6.1.хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;

11.6.2.монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.

11.7.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах газар зүйн нэрийг Засгийн газар нэгтгэн Улсын Их Хурлаар батлуулна.

11.8.Монгол улсын **үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд** орон тооны бус газар зүйн нэрийн Үндэсний зөвлөл ажиллана.

11.9.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг **Засгийн газар** батална.

11.10.Газар зүйн нэрийг шинээр өгөх, өөрчлөх асуудлыг Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл Улсын Их Хуралд өргөн барьж шийдвэрлүүлнэ.

11.11.Газар зүйн нэрийг 10 жил **тутамд** шалгаж, тодотгон баталгаажуулна.

11.12.Газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, **газар зүйн** нэрийн зураг үйлдэх, мэдээллийн сан үүсгэх, жагсаалт хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, зөв бичих, газрын зурагт тусгах, галиглах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан норм, дүрэм, журмыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

12 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх

12.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхэлнэ.

12.2.Геодези, зураг зүйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, ~~мэргэжлийн боловсон хүчин салбарын хүний нөөц~~, геодезийн хэмжлийн багаж, ~~хэрэгслийг~~ геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ.

12.3.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох ба энэ чиг үүргийг ~~Засгийн газрын~~ шийдвэрийн үндсэн дээр мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

12.4.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Геодезийн болон Зураг зүйн төрлөөр олгоно.

12.5.Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна:

12.5.1.Геодезийн ~~хоёр~~ инженертэй байх ба нэг нь Зөвлөх эсвэл мэргэшсэн инженер байх;

12.5.2.Геодезийн хэмжлийн дараахь-багажтай байна: Тахеометр ~~±2 секунд~~ ба түүнээс дээш нарийвчлалтай, хиймэл дагуулын ~~хоёр долгионы~~ геодезийн хэмжилтийн хос багаж ~~/3см+1ppm/~~, ~~±2мм-миллиметр~~ ба түүнээс илүү нарийвчлалтай нивелир.

12.6. Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь Зөвлөх эсвэл мэргэшсэн зураг зүйч инженертэй байна.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

13.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор шийдвэрлэнэ.

13.2.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

13.3.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг ~~мөн~~ гурван жилийн хугацаагаар сунгаж болно.

~~13.4.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн бүрдүүлж өгнө:~~

~~13.4.1.инженер, техникийн ажилтан тус бүрийн диплом, иргэний үнэмлэх;~~

~~13.4.2.зөвлөх инженер, мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээ;~~

~~13.4.3.геодезийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын гэрчилгээ;~~

~~13.4.4.үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичиг;~~

~~13.4.5.инженер, техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын цахим лавлагаа.~~

~~13.5.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад бүрдүүлэх баримт бичиг:~~

~~13.5.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт;~~

~~13.5.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг дүгнэсэн тэмдэглэл;~~

~~13.5.3. энэ хэсгийн 13.4 дэх хэсэгт дурдсан баримт бичиг.~~

13.6. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдуулан энэ хуулийн 13.4-т зааснаас бусад баримт бичгийг шаардахыг хориглоно.

13.7. Дараахь тохиолдолд геодези, зураг зүйн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

13.7.1. энэ хуулийн 7-12 дугаар зүйл, 22.1-д тавьсан шаардлагыг зөрчсөн;

13.7.2. тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хоёр жил дараалан эрхлээгүй.

13.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны мэдээ, тайланг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

14 дүгээр зүйл. Улсын их хурлын бүрэн эрх

14.1. Улсын их хурал геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

14.1.2. улсын хилийн шугамын дагуух байр зүйн зураг, хилийн тэмдэгтийн солбицол, өндөр, хилийн цэсийг батлах;

14.1.3. газар зүйн нэрийг батлах;

14.1.4.1:25 000 болон түүнээс том масштабтай байр зүйн зурагт дүрсэлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зураг, солбицлын жагсаалтыг батлах;

15 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

15.2. Засгийн газар геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.2.1. геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндрийн тогтолцоо, тусгаг, геодезийн эхлэл цэгийн өгөгдөхүүнийг батлах;

15.2.2. олон улсын баримт бичигт тусгах, газрын зурагт хэрэглэгдэх Монгол Улсын газар зүйн нэр, засаг захиргааны нэгжийн хил, түүний өөрчлөлтийн талаархи мэдээллийг холбогдох олон улсын байгууллагатай солилцох;

15.2.3. төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

15.2.4. геодези, зураг зүйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

15.2.5. газар зүйн нэрийн үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;

15.2.6. Монгол улсын нутаг дэвсгэрт бүх салбарын хэмжээнд гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын нэгдсэн зохицуулалт хийх, бүртгэх журмыг батлах;

15.2.7. геодези, зураг зүйн ажилд магадлал хийх журмыг батлах;

15.2.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгуулах улсын геодезийн байрлал, өндөр, гравиметрийн цэг тэмдэгтийн нягтралын хэмжээг тогтоох.

16 дугаар зүйл. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

16.3.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.3.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

16.3.2.геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

16.3.3.Монгол Улсын геодезийн тулгуур сүлжээг нягтруулах, шинэчлэх, нутаг дэвсгэрийг зурагжуулах төрөөс баримтлах бодлогыг боловсруулах;

16.3.4.геодези, зураг зүйн үйл ажиллагаанд баримтлах журам, норматив баримт бичгийг батлах, мөрдүүлэх;

16.3.5.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

16.3.6.Аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, цуцлах, тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тодорхойлсон журмыг баталж, мөрдүүлэх;

16.3.7.Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ, үнийн индекс батлах;

16.3.8.Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох;

16.3.9.Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох журмыг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

16.3.10.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник эдийн засгийн үндэслэл, техникийн төслийг батлах;

16.3.11.Геодези, зураг зүйн мэргэжлийн боловсон хүчний бодлогыг эрхлэх;

17 дугаар зүйл.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

17.1.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй газрын зургийн зохиолт, хадгалалтыг хариуцдагийн хувьд төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;

17.1.2.энэ хуулийн 5.1.1-5.1.18-д заасан үйл ажиллагааг эрхлэх, мэргэжлийн удирдлагаар хангах;

17.1.3.энэ хуулийн 5.1.19-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;

17.1.4.геодези, зураг зүйн үйл ажиллагаанд мөрдөх солбицол, өндрийн тогтолцоо, тусгагийг боловсруулж, хэрэгжүүлэх;

17.1.5.геодезийн сүлжээний хэмжилтийн өгөгдлийг солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоонд тэгшитгэн бодох, шилжүүлэх, солбицлын тогтолцоо хооронд хөрвүүлэх;

17.1.6.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөлийг боловсруулах, энэхүү ажлын бүртгэл хөтлөх, ажлын даалгаварыг боловсруулах, баталж хэрэгжүүлэх, хянах;

17.1.7.геодезийн байнгын цэг, тэмдэгт суулгах, нөхөн сэргээх, хадгалах хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих;

17.1.8.геодезийн хэмжилтийн хиймэл дагуулын байнгын ажиллагаатай станцын сүлжээ байгуулах, өргөтгөх, хэвийн ажиллагааг хангах, ашиглуулах;

17.1.9.газрын зураг, атласыг **зохиох, хэвлүүлэх**, олгох, худалдах, хэвлэмэл зургийг шилжүүлэх, шинэчлэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

17.1.10.тусгай зориулалтын газрын зургийн зохиолт, хэвлэлт, ашиглалт, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хянах, шалгах;

17.1.11.геодези, байр зүй, зураг зүйн **хэмжлийн** багаж, хэрэгсэл баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, багажны бүртгэлийн мэдээллийн сан хөтлөх;

17.1.12.геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ, үнийн индекс, норм, дүрэм, журам боловсруулах;

17.1.13.геодези, зураг зүйн заавар, аргачлал батлах, стандарт боловсруулж мөрдүүлэх;

17.1.14.газрын зургийн нэг маягийн суурийг зохиох, батлах, хэрэглээнд хяналт тавих;

17.1.15.бүх төрлийн сэдэвчилсэн **газрын** зураг, атласын зохиолтын эхэд мэргэжлийн дүгнэлт өгөх;

17.1.16.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлыг улсын нэрийн өмнөөс шалгаж хүлээн авч геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд төвлөрүүлэх;

17.1.17.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх;

17.1.18.геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийх ажлыг зохион байгуулах;

17.1.19.геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

17.1.20.геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

17.1.21.геодези, зураг зүйн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

~~Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох сургалт зохион байгуулах;~~

17.1.22.тусгай зориулалтын газрын зураглалын ажилд Тагнуулын байгууллагатай хамтран хяналт тавих;

17.1.23.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник эдийн засгийн үндэслэл, техникийн төслийг хянах, боловсруулах.

17.2.Салбарын мэргэжилтнүүдийг бүртгэх, геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийх, салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах чиг үүргийг **Засгийн газрын** шийдвэрийн үндсэн дээр төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

18 дугаар зүйл.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг

18.1.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийн биелэлтийг харъяалсан салбартаа зохион байгуулах;

18.1.2.салбарын хүрээнд дараа жил хийгдэх геодези, зураг зүйн ажлын саналыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх;

18.1.3.өөрийн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах, геодези, зураг зүйн үйл ажиллагааны журмыг мөрдөх;

18.1.4.салбарын орон зайн мэдээллийн санг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээлэлтэй уялдуулах ажлыг зохион байгуулах;

18.1.5.газрын зурагт тусгах салбарын мэдээ, мэдээллээр хангах;

18.1.6.салбарын хэмжээнд гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын даалгавар, техникийн төслийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулах;

18.1.7.сургалтын газрын зураг, атласын хэрэгцээ, шаардлага, агуулгыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох;

18.1.8.геодезийн хэмжилтийн хиймэл дагуулын байнгын ажиллагаатай станцыг байгуулж, ашиглаж болох бөгөөд техникийн төслийн үндсэн дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр холбогдох норм, дүрмийг баримтлан гүйцэтгүүлэх;

18.1.9.байнгын ажиллагаатай станцын өгөгдлийг тогтмол хугацаанд геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх;

18.1.10.Зэвсэгт хүчний жанжин штаб цэргийн зориулалтаар хийж буй геодези, газрын зургийн ажилд хяналт тавина.

19 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

19.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

19.1.2.нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын талаархи мэдээлэл, нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих, тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

19.1.3.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн харьяа нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих;

19.1.4.нутаг дэвсгэртээ хамаарах батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал дэвшүүлэх;

19.1.5.нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн болон дэвсгэр зургийг шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

19.1.6.орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, газрын зургийн ажлын техникийн даалгавар, техникийн төслийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулах;

19.1.7.геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийлгэх.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ

20 дугаар зүйл. Иргэн, төрийн бус байгууллагын оролцоо

20.1. Геодези, зураг зүйн чиглэлийн төрийн бус байгууллага нь төрийн зарим чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр гэрээгээр гүйцэтгэж болно.

20.2.Холбогдох хууль тогтоомж, стандарт, норматив баримт бичиг, эрх зүйн бусад баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр санал өгөх эрхтэй.

20.3.Иргэн, төрийн бус байгууллага геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичигт санал өгч болно.

21 дүгээр зүйл. Захиалагчийн чиг үүрэг

21.1. Геодези, зураг зүйн ажил захиалагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.4.1-д заасны дагуу үйл ажиллагааныхаа талаар тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргаа, иргэдэд мэдээлэх;

21.1.2.улсын магадлалын дүгнэлтийг биелүүлэх;

21.1.3.энэ хуулийн 5.1-д заасан үйл ажиллагааны захиалагч нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ажлын үр дүнг геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлэх;

21.1.3.Энэ хуулийн 9.4-д заасан нэгдсэн санд байгаа мэдээллийг ашиглах;

21.1.3.Энэ хуулийн 9.7-д заасан мэдээллийг шаардах;

21.1.3.норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах;

21.1.3.геодези, зураг зүйн ажилд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах;

21.1.3.геодези, зураг зүйн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан зохицуулж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх;

21.1.3.геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гарах эрсдэл, хохирлыг хариуцах;

22 дугаар зүйл. Аж ахуй нэгжийн чиг үүрэг

22.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь дараах эрх, үүрэгтэй:

22.1.1.Энэ хуулийн 6.1-д хэсэгт заасан эрх үүрэг;

22.1.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

22.1.1.геодезийн хэмжлийн багажиндаа жил бүр, эвдрэл, гэмтэл гарсан нөхцөлд тухай бүр баталгаажуулалт хийлгэх;

22.1.1.геодезийн хэмжилт, зураглалыг улсын болон бие даасан солбицол, өндөр, тусгагийн тогтолцоонд хийх;

22.1.1.геодези, зураг зүйн тухай хууль, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, журам, стандарт, норматив баримт бичгийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

22.1.1.нийтийн хэрэгцээнд зориулан гаргах төрөл бүрийн сэдэвчилсэн, лавлагааны, сургалтын газрын зураг, атлас зохиох, хэвлэхдээ геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байх;

22.1.1.сургалтын болон сэдэвчилсэн зураг, атлас зохиохдоо нэг маягийн суурь зураг ашигласан байх;

22.1.1.энэ хуулийн 7.7-д заасан зардлыг геодези, зураг зүйн ажлын төсөвт өртөгт тусгасан байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ХЯНАЛТ

23 дугаар зүйл. Геодези, зураг зүйн улсын хяналт

23.1.Геодези, зураг зүйн улсын хяналт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан норматив баримт бичгийн биелэлтийг хангана.

23.2.Геодези, зураг зүйн улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэлдажиллах геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

23.3.Геодези, зураг зүйн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

24 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд магадлал хийх

24.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагааны магадлалыг батлагдсан журмын дагуу, ажлын 15 хоногт багтаан хийнэ.

24.2.Магадлалыг дараахь геодези, зураг зүйн ажлын үр дүнд хийнэ:

24.2.1.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгавар;

24.2.2.геологийн дунд масштабын зураглалын геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

24.2.3.уул уурхайн ашиглалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

24.2.4.хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө зохиоход ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

24.2.5.инженерийн дэд бүтцийн томоохон байгууламжийн төлөвлөлт, байгуулалтад ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл.

24.3.Энэ хуулийн 24.2 дахь хэсэгт гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан геодези, зураг зүйн бүтээгдэхүүнд нэгэн адил хамаарна.

24.4.Энэ хуулийн 24.2, 24.3-т заасан ажлын үр дүнд магадлал хийлгээгүй бол геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээн авахыг хориглоно.

24.5. энэ хуулийн 24.2.1-д дурдсан ажлын даалгавар, техникийн төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан баримт бичигт дахин магадлал хийлгэнэ.

24.6.Магадлалын дүгнэлт татгалзсан, зөвшөөрсөн гэсэн хоёр хэлбэртэй байна. Магадлалын татгалзсан дүгнэлт геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

24.7.Энэ хуулийн 24.6-д заасан магадлалын дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлж болно.

24.8.Захиалагчийн хүсэлтээр геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН УЛСЫН НЭГДСЭН САН

25 дугаар зүйл. Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөг

25.1.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид “нэгдсэн сан” гэх/ нь геодезийн сүлжээний, байр зүйн зургийн, агаар, сансрын зургийн, газар зүйн нэрийн болон кадастрын тухай мэдээлэл, тэдгээртэй холбогдох бусад тоон мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан хөмрөг нь төрийн өмч байна.

25.2.Иргэн, хуулийн этгээд нь улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагын хэрэгжүүлж буй төслийн хөрөнгө, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн

геодези, зураг зүйн ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт (каталог), бүдүүвч зураг, бичлэг, бусад тоон мэдээллийг нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

25.3.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аж ахуйн нэгж, иргэний хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, бусад материалыг худалдан авч болно.

25.4.Нэгдсэн сан хөмрөг нь дараахь зүйлээс бүрдэнэ:

25.4.1.Энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны үр дүнд үүссэн газрын зураг, хэвлэлийн эх, гэрэл зургийн хальс, тайлан, солбицлын жагсаалт (каталог), бусад тоон мэдээлэл;

25.4.2.энэ хуулийн 25.2-т заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн материал;

25.4.3.бусдад худалдах, олшруулах эрхгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан, энэ хуулийн 9.4.1, 9.4.2-т зааснаас бусад онц чухал материал;

25.4.4.байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс өөрсдийн үйл ажиллагаа, бүтээлийг сурталчлах зорилгоор нэгдсэн санд ирүүлж байгаа зураг, тоон мэдээлэл, тоног төхөөрөмжийн тухай танилцуулга.

25.5.Энэ хуулийн 25.4-т заасан мэдээллийг хүлээн авах, нийтэд үйлчлэх журмыг энэ хууль, Төрийн болон албаны нууцын тухай болон Архивын тухай хуульд нийцүүлэн геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

25.6.Нэгдсэн сангийн мэдээллийн мета-өгөгдлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлэх үүрэгтэй.

25.7.Нэгдсэн сангийн мэдээллийн мета-өгөгдөл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

25.7.1.мэдээллийн нэр, товч тайлбар;

25.7.2.мэдээллийн чанарын тодорхойлолт;

25.7.3.мэдээллийн үндсэн эх сурвалж;

25.7.4.мэдээллийн дүрслэл, солбицлын тогтолцоо;

25.7.5.мэдээллийн хэрэглээ, түгээлт.

25.8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.4.2-д заасан мэдээллийг мета-өгөгдлийн хамт шилжүүлнэ.

25.9. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт газрын зураг захиалж хийлгэхдээ урьд өмнө нь тухайн газар нутагт геодези, зураг зүйн ажил хийгдэж байсан эсэхийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангаас нягтлана.

25.10. Геодези, зураг зүйн өгөгдөл, бүтээгдэхүүнийг нэгдсэн портал сайтаар дамжуулан нийтийн хүртээл болгоно.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. БУСАД ЗҮЙЛ

26 дугаар зүйл. Санхүүжилт

26.1.Улсын захиалга, даалгавраар хийх геодези, зураг зүйн ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

26.2.Геодези, зураг зүйн улсын чанартай ажлын захиалагч нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд жил бүр улсын захиалга, даалгаврыг боловсруулж улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

26.3.Тухайн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь холбогдох төрийн захиргааны байгууллага, орон нутагт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь тухайн шатны засаг дарга байна.

26.4.Геодезийн байнгын цэг тэмдэгтийг хамгаалах, тооллого хийх нөхөн сэргээхтэй холбоотой зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

26.5.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний захиалгаар хийгдэх геодези, зураг зүйн ажлыг захиалагчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

26.6.Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, гудамж, зам, талбай, шугам сүлжээний холболт, мод цэцэрлэгжүүлэлтийг шинээр хийх, өөрчлөх, нөхөн сэргээх зэрэг газар шорооны ажил хийсэн талбайд гүйцэтгэлийн байр зүйн зураг хийлгэх, түүнд шаардагдах зардлыг захиалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

26.7.Геодези, зураг зүйн норм, норматив баримт бичиг боловсруулах сантай байна.

26.8.Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө захиалгаар хийгдэж буй геодези, зураг зүйн ажлын нийт төсөвт өртгийн 6 хувийг захиалагчийн хяналт шалгалтад, 1 хувийг энэ хуулийн 26.7-д заасан санд төвлөрүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа

27.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дараах геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

27.1.1.энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр геодезийн цэгийг шилжүүлэх, устгах, гэмтээх, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулах;

27.1.2.газар зүйн албан ёсны нэрийг өөрчлөн хэрэглэх, гадаад хэлэнд орчуулах;

~~зөхих хууль тогтоомжид заасан журмыг зөрчин байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хийсэн зураг зүйн бүтээлийг хуулбарлах, олшруулах, хэвлэх.~~

27.1.3.геодезийн хэмжлийн баталгаажуулаагүй багаж ашиглах;

27.1.4.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх;

27.1.5.нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг холбогдох төрийн захиргааны байгууллагын хяналтгүйгээр хэвлэх, хуулбарлах, олшруулах;

27.2. Гадаадын хуулийн этгээд монгол улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

28 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх

28.1.Геодезийн хэмжилт хийх, цэг байгуулах явцад газар, барилга байгууламж, бусад объектод учруулсан хохирлыг тухайн үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө.

28.2.Гүйцэтгэсэн ажлын нарийвчлал, стандартын шаардлага хангагдаагүйгээс учирсан шууд хохирлын нөхөн төлбөрийг гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

28.3.Геодезийн цэгийг устгасан, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан бол буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээнэ.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2019 оны ..дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ